



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/05/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зууныот, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tov@audit.gov.mn

2022.02.25 № 01/56
Тайлан -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА С.ӨЛЗИЙБАТ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлж гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц ХИШИГЖАРГАЛ

19020240

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	106,818,936.26	88,509,798.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	719,209.96	599,678.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	719,209.96	599,678.49
3121	Төгрөг	719,209.96	599,678.49
31211	Төрийн сангийн харилцах	719,209.96	599,678.49
33	АВЛАГА	58,778,482.00	27,816,799.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	16,799.95
335	Бусад авлага	58,778,482.00	27,800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	58,778,482.00	27,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47,321,244.30	60,093,319.95
351	Түүхий эд материал	3,894,833.80	17,208,976.85
35110	Тусгай зориулалттай материал	3,592,166.00	15,969,521.00
35130	Эм боох материал	302,667.80	1,239,455.85
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,169,842.20	3,838,915.40
354	Хангамжийн материал	39,256,568.30	39,045,427.70
35410	Бичиг хэргийн материал	899,391.00	871,391.00
35420	Аж ахуйн материал	6,802,160.00	7,057,960.00
35440	Түлш, шатах тослох материал	373,000.00	-
35460	Хүнсний материал	1,745,017.30	2,029,476.70
35470	Бусад хангамжийн материал	29,437,000.00	29,086,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	319,708,570.55	345,820,636.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	319,708,570.55	345,820,636.44
392	Биет хөрөнгө	252,493,826.87	278,421,782.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	160,370,800.50	191,456,355.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,990,980.96)	(57,282,482.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,980,000.00	82,957,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(92,064,445.01)	(71,414,320.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	208,529,168.99	218,416,815.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,219,446.91)	(100,608,878.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,043,894.42	21,017,866.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,187,838.80)	(10,982,047.51)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,246,324.00	4,246,324.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,948,500.00	1,468,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,162,149.36)	(853,349.24)
393	Биет бус хөрөнгө	67,214,743.68	67,398,854.13
39301	Програм хангамж	6,417,692.31	4,070,192.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,177,948.63)	(3,646,338.18)
39303	Бусад биет бус хөрөнгө	66,975,000.00	66,975,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	426,527,506.81	434,330,434.83

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	719,209.96	552,880.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	719,209.96	552,880.00
413	Өглөг	719,209.96	552,880.00
4136	Бусад өглөг	719,209.96	552,880.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	719,209.96	552,880.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	425,808,296.85	433,777,554.83
51	Засгийн газрын хувь оролцоо	425,808,296.85	433,777,554.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	231,880,081.77	231,880,081.77
51101	Өмч: - төрийн	231,880,081.77	231,880,081.77
512	Хуримтлагдсан үр дүн	(53,380,326.67)	(45,283,948.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(53,380,326.67)	(53,253,206.79)
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,969,257.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	247,308,541.75	247,181,421.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	426,527,506.81	434,330,434.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	791,967,051.38	837,901,355.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,674,751.38	62,632,055.99
120	Нийтлэг татварын бус орлого	61,674,751.38	62,632,055.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,674,751.38	62,632,055.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,460,751.38	62,632,055.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	730,292,300.00	775,269,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	730,292,300.00	771,669,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	730,292,300.00	771,669,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,600,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	774,275,657.80	829,932,098.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,275,657.80	829,932,098.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	773,108,445.75	827,293,852.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,882,309.45	559,022,801.51
210101	Үндсэн цалин	330,906,209.45	351,560,688.11
210102	Нэмэгдэл	175,976,100.00	194,250,113.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	13,212,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,172,309.23	12,571,097.84
210201	Тэтгэврийн даатгал	-	1,377,346.91
210202	Тэтгэмжийн даатгал	-	120,477.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	150,597.38
210204	Ажилгүйдлийн даатгал	-	30,119.45
210205	Эрүүл мэндийн даатгал	14,172,309.23	10,892,556.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,563,632.00	88,220,417.90
210301	Гэрэл, цахилгаан	14,800,000.00	16,533,681.90
210302	Түлш, халаалт	49,250,432.00	49,250,432.00
210303	Цэвэр, бохир ус	21,513,200.00	22,436,304.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,534,091.80	15,461,076.80
210401	Бичиг хэрэг	3,738,009.00	2,779,650.00
210402	Тээвэр, шатахуун	9,731,030.00	8,985,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,995,200.00	2,297,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,400.00	170,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,899,452.80	1,227,726.80
2105	Нормативт зардал	54,387,313.70	41,933,252.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,450,748.00	4,776,311.95
210502	Хоол, хүнс	51,936,565.70	37,156,940.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,138,718.00	35,284,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	282,700.00
210604	Урсгал засвар	12,138,718.00	35,002,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,558,900.00	5,016,839.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	2,576,000.00	3,047,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	367,600.00	367,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	352,700.00	339,239.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	174,600.00	174,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,871,171.57	69,783,567.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	819,000.00	1,728,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	352,500.00	305,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,699,671.57	67,749,467.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,167,212.05	2,638,245.31
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	462,000.00	352,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	462,000.00	352,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	705,000.00	378,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	378,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	212.05	1,907,445.31
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212.05	1,907,445.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	17,691,393.58	7,969,257.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	17,691,393.58	7,969,257.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	739,488,893.95	779,350,923.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,696,806.00	5,989,068.49
120	Нийтлэг татварын бус орлого	8,696,806.00	5,989,068.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,696,806.00	4,766,270.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,696,806.00	4,766,270.00
120009	Бусад орлого	-	1,222,798.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	730,792,087.95	773,361,854.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	730,292,087.95	769,761,854.69
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	730,292,087.95	769,761,854.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	3,600,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	-	3,600,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	740,785,893.63	779,470,454.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	740,785,893.63	779,470,454.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,618,893.63	778,739,654.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,382,309.45	560,245,600.00
210101	Үндсэн цалин	330,906,209.45	352,783,486.60
210102	Нэмэгдэл	175,976,100.00	194,250,113.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,000,000.00	13,212,000.00
210104	Урамшуулал	1,500,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,166,059.50	12,587,897.79
210201	Тэтгэврийн даатгал	-	1,377,346.91
210202	Тэтгэмжийн даатгал	-	120,477.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	150,597.38
210204	Ажилгүйдлийн даатгал	-	30,119.45
210205	Эрүүл мэндийн даатгал	14,166,059.50	10,909,356.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,242,919.00	88,220,417.90
210301	Гэрэл, цахилгаан	14,800,000.00	16,533,681.90
210302	Түлш, халаалт	45,929,719.00	49,250,432.00
210303	Цэвэр, бохир ус	21,513,200.00	22,436,304.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,939,400.00	13,606,300.00
210401	Бичиг хэрэг	1,750,400.00	2,096,600.00
210402	Тээвэр, шатахуун	9,478,200.00	8,395,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,995,200.00	2,297,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,400.00	170,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	545,200.00	645,800.00
2105	Нормативт зардал	43,414,400.00	37,411,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,786,900.00	3,272,700.00
210502	Хоол, хүнс	41,627,500.00	34,138,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,931,600.00	54,684,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	21,900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	314,400.00	282,700.00
210604	Урсгал засвар	43,117,200.00	32,502,100.00
2107	Томилолт, зочны зардал	32,000.00	-
210702	Догоод албан томилолт	32,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,338,705.68	9,949,438.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	12,355,805.68	7,979,999.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	367,600.00	367,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	352,700.00	339,239.00

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	174,600.00	174,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,171,500.00	2,034,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	819,000.00	1,728,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	352,500.00	305,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,167,000.00	730,800.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	462,000.00	352,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	462,000.00	352,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	705,000.00	378,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	378,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,296,999.68)	(119,531.47)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,296,999.68)	(119,531.47)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,016,209.64	719,209.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	719,209.96	599,678.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,339,277.75	-66,511,686.25	412,707,673.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	157,855.88	157,855.88
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,880,081.77	247,339,277.75	-66,353,830.37	412,865,529.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-157,855.88	00.00	-157,855.88
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	13,100,623.58	13,100,623.58
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,181,421.87	-53,253,206.79	425,808,296.85
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,023,565.99	-40,152,583.21	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	127,119.88	127,119.88
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,880,081.77	247,181,421.87	-53,126,086.91	425,935,416.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-127,119.88	00.00	-127,119.88
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,969,257.98	7,969,257.98
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,054,301.99	-45,156,828.93	433,777,554.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	771,883,300.00	779,470,454.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,883,300.00	779,470,454.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	771,044,500.00	778,739,654.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,245,600.00	560,245,600.00
210101	Үндсэн цалин	320,803,100.00	352,783,486.60
210102	Нэмэгдэл	234,498,500.00	194,250,113.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,024,000.00	13,212,000.00
210104	Урамшуулал	1,920,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,380,100.00	12,587,897.79
210201	Тэтгэврийн даатгал	-	1,377,346.91
210202	Тэтгэмжийн даатгал	-	120,477.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	150,597.38
210204	Ажилгүйдлийн даатгал	-	30,119.45
210205	Эрүүл мэндийн даатгал	14,380,100.00	10,909,356.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,227,600.00	88,220,417.90
210301	Гэрэл, цахилгаан	16,534,000.00	16,533,681.90
210302	Түлш, халаалт	49,250,700.00	49,250,432.00
210303	Цэвэр, бохир ус	22,442,900.00	22,436,304.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,820,300.00	13,606,300.00
210401	Бичиг хэрэг	2,310,600.00	2,096,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,395,900.00	8,395,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,297,600.00	2,297,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,400.00	170,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	645,800.00	645,800.00
2105	Нормативт зардал	37,411,100.00	37,411,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,272,700.00	3,272,700.00
210502	Хоол, хүнс	34,138,400.00	34,138,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,084,800.00	54,684,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,300,000.00	21,900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	282,700.00	282,700.00
210604	Урсгал засвар	32,502,100.00	32,502,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,016,900.00	9,949,438.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	3,047,400.00	7,979,999.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	367,600.00	367,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	339,300.00	339,239.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	174,600.00	174,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	858,100.00	2,034,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	552,600.00	1,728,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	305,500.00	305,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	838,800.00	730,800.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	460,800.00	352,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	460,800.00	352,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	378,000.00	378,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	378,000.00	378,000.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	771,883,300.00	778,343,015.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	771,669,300.00	773,576,745.31
131001	Улсын төсвөөс санхүүжих	771,669,300.00	773,576,745.31
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	214,000.00	4,766,270.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,000.00	4,766,270.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	719,209.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	599,678.49

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,600,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,600,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,600,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,600,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	-	3,600,000.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	719,209.96
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	599,678.49

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд И баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Хууль зүйн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах
- Эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэгтгэн зохион байгуулах
- Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, удирдлагын манлайллыг хангах, хяналт-шинжилгээ хийх, үнэлж дүгнэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/10 тушаалаар "Дотоод хяналт шалгалт явуулах" ажлын хэсэг болон 2021 оны дотоод хяналт шалгалт ажлын төлөвлөгөө хуваарийг баталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Дотоод хяналтын хороо нь 2021 оны жилийн ажлын төлөвлөгөөнд сахилга хариуцлага, үүргийн хэрэгжилтийн талаар 8 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 11,879.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,503.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,5 хувиар буюу 12,568.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,054.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 551,211.6 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 779,470.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 214.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 4,766.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 2227 хувийн

биелэлттэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд 3,600.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 779,350.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд ШШГЕГ-аас 3,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Төв аймаг дахь Цагдаагийн газраас 107.1 мянган төгрөгийн агуулахын барилга, Зуунмод сумын ЗДТГ-аас 4,402.1 мянган төгрөгийн тавилга, Аймгийн ИТХ-аас 20,758.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж ирснийг бүртгэж тайлагнасан байна. ШШГЕГ-ын даргын тушаал, ТӨБЗГ-ын 54 дүгээр тогтоолоор нийт 83,764.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд ШШГЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 16,526.4 мянган төгрөг, ОБГ-аас 1,140.0 мянган төгрөг, Сод интернэшнл ХХК, Зуунмод сумын ЗДТГ-аас 3,922.6 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 81,789.7 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 90,666.6 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага 27,816.0 мянган төгрөг, 552.9 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь Тариат харз ХХК-тай холбоотой 27,800.0 мянган төгрөгийн авлага байгаа бөгөөд Хан уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 354 дүгээр шийдвэр гарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайланд төрийн сангийн хоригдол нэрийн 100140012502 дугаарын дансанд 522.9 мянган төгрөгийн, ахмадын сангийн дансанд 46.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага данс 27.8 мянган төгрөг, бараа материал 60,093.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 345,820.64 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	719.21	599.68	119.53
Авлага	58,778.48	27,816.80	30,961.68
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	47,321.24	60,093.32	(12,772.08)
Үндсэн хөрөнгө	319,708.57	345,820.64	(26,112.07)
Нийт хөрөнгө	426,527.51	434,330.43	(7,802.93)
Өр төлбөр	719.21	552.88	166.33
Засгийн газрын оролцоо	425,808.30	433,777.55	(7,969.26)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	426,527.51	434,330.43	(7,802.93)

Авлагын дансны үлдэгдэлд шүүхийн шийдвэр гарсан Тариат харз ХХК-тай холбоотой 27,800.0 мянган төгрөгийн авлага 99 хувийг эзэлж байна. Бараа материалын дансны үлдэгдэл 60,093.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,772.1 мянган төгрөгөөр өссөн нь ШШГЕГ-аас 16,526.4 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 955,231.9 мянган төгрөг болж 225,922.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 93,861.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 433,777.6 мянган төгрөг болж 7,969.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 780,057.8 мянган төгрөгөөр төлөвлөн 2020 оны 07 сарын 09-ний өдрийн 1/124 дугаар албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8,388.5 мянган төгрөгөөр бууруулан 771,669.3 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 769,761.8 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагаанд 758,029.1 мянган төгрөг, шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээнд 8,836.0 мянган төгрөг, тэтгэмжид 730.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ШШГЕГ-аас 3,600.0 мянган төгрөгийн санхүүжилт өгч Смарт зон ХХК-иас ухаалаг самбар авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 2021 онд төсвийн хөрөнгөөр 21,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Цалингийн зарцуулагдаагүй үлдэгдлээс ахмадын сангийн 100140012504 дугаарын дансанд 1,222.8 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №1/784 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилт, авлага барагдуулалтыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43,114.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 35,060.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,222.8 мянган төгрөгийн албан шаардлага, 6,831.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

4.1.1 Санхүү тайланг санхүүгийн программын алдаанаас шалтгаалан 35,060.1 мянган төгрөгийн зөрүүтэй татагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх,

зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэн залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

4.2.1 Цалингийн зарцуулагдаагүй үлдэгдлээс ахмадын сангийн 100140012504 дугаарын дансанд 1,222.8 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3-д “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.3-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Анхан шатны баримттай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг Татварын е баримт, е постын дүнтэй тулгалт хийхэд 6,831.6 мянган төгрөгийн гүйлгээний Е баримт зөрүүтэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг зааврын дагуу бүрэн хөтөлж, хэвших ба худалдан авалт хийх бүрд и-баримтыг бүрдүүлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	3	43.1	1	35.1			1	1.2	1	6.8